



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/367

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Европын холбоо болон ХБНГУ-ын Засгийн газрын санхүүжилттэй, Нэгдсэн үндэстний байгууллагын (НҮБ) Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран хэрэгжүүлэх “Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” төслийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслийн багийнхан Хэнтий аймагт ажиллахтай холбогдуулан 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгаагүй нэг удаагийн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2021 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Мөнгөн дүн
1	Бэлэг дурсгал	5 хүн	200,000	1,000,000
2	Хүндэтгэлийн зоог			1,200,000
Нийт үнэ				2,200,000